БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2022/75/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Булган аймаг<br>2022 он | Булган аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр<br>Утас:70342580 Цахим хаяг:ankhbayard@audit.gov.mn<br><br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас:70342716 Цахим хаяг:enkhtsoodolj@audit.gov.mn<br><br>Аудитор: Э.Одбаясах<br>Утас:99889486 Цахим хаяг: odbayasakhe@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1. Аудитын санал дүгнэлт ....2
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ....4
3. Аудитын тайлан....12
   3.1 Ерөнхий зүйл....12
   3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ....13
   3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ....13
   3.4 Материаллаг байдал ....13
   3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга....13
   3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв....13
   3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг....15
   3.8 Аудитын гол асуудал ....15
   3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....15
   3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....15
   3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал....16
4. Аудитын илрүүлэлт ....16
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ....16

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

Аудитын санал дүгнэлт:

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-3259
E-mail:bulgan@audit.gov.mn

2022.02.25 № 117

танай________ны №________т

СЭЛЭНГЭ СУМЫН СОЁЛЫН ТӨВИЙН ЭРХЛЭГЧ П.ХОНГОРЗУЛ ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

D:/bichighereg/2022A4toot

006020232

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

D:/bichighereg/2022A4toot

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **16,073,960.00** | **17,854,740.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | - |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 16,073,960.00 | 17,854,740.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 16,073,960.00 | 17,854,740.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 16,073,960.00 | 17,854,740.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **163,263,788.10** | **1,023,359,912.03** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 163,263,788.10 | 1,023,359,912.03 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 163,263,788.10 | 1,022,526,578.73 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 160,528,747.75 | 1,024,011,779.75 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (17,032,978.32) | (26,748,749.47) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 23,609,503.70 | 30,232,003.70 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (21,027,503.84) | (22,178,503.62) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 14,145,510.20 | 15,236,010.20 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (9,442,552.39) | (10,509,022.83) |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | 12,483,061.00 | 12,483,061.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | - | 833,333.30 |
| 39301 | Програм хангамж | - | 1,000,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (166,666.70) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **179,337,748.10** | **1,041,214,652.03** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | - | - |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **179,337,748.10** | **1,041,214,652.03** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 179,337,748.10 | 1,041,214,652.03 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 48,626,586.94 | 48,626,586.94 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (15,874,289.11) | 846,002,614.82 |

| | | | |
|---|---|---|---|
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (15,874,289.11) | (15,874,289.11) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | 861,876,903.93 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 146,585,450.27 | 146,585,450.27 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **179,337,748.10** | **1,041,214,652.03** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **78,276,400.00** | **83,297,400.00** |
| **11** | **ТАТВАРЫН ОРЛОГО** | **-** | **-** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **150,000.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 150,000.00 | - |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 150,000.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 150,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **78,126,400.00** | **83,297,400.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 5,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 5,000,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 78,126,400.00 | 78,297,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 78,126,400.00 | 78,297,400.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **89,593,294.76** | **88,366,528.07** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **89,593,294.76** | **88,366,528.07** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 86,591,588.76 | 87,954,596.07 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 58,154,499.20 | 60,913,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 45,090,792.20 | 51,306,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 13,063,707.00 | 9,607,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,650,244.00 | 7,785,820.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,639,402.00 | 4,927,810.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 550,553.00 | 911,923.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 441,692.00 | 401,867.22 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 121,100.00 | 226,987.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 897,497.00 | 1,317,231.64 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 7,396,067.00 | 6,024,848.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,092,467.00 | 1,264,848.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,303,600.00 | 4,760,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 297,000.00 | 325,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 60,000.00 | 60,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 112,500.00 | 100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 85,000.00 | 75,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 90,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 39,500.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 32,000.00 | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 32,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 300,000.00 | 340,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | - |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 40,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 300,000.00 | 300,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 68,400.00 | 56,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 68,400.00 | 56,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,528,000.00 | 408,720.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,420,000.00 | 408,720.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 12,165,378.56 | 12,099,908.07 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 12,165,378.56 | 12,099,908.07 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 3,001,706.00 | 411,932.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 200,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,701,706.00 | 211,932.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,701,706.00 | 211,932.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(11,316,894.76)** | **861,876,903.93** |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | - | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(11,316,894.76)** | **861,876,903.93** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **48,626,586.94** | **146,585,450.27** | **(15,874,289.11)** | **-** | 179,337,748.10 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **48,626,586.94** | **146,585,450.27** | **(15,874,289.11)** | **-** | 179,337,748.10 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **48,626,586.94** | **146,585,450.27** | **(15,874,289.11)** | **-** | 179,337,748.10 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | 861,876,903.93 | | 861,876,903.93 |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **48,626,586.94** | **146,585,450.27** | **846,002,614.82** | **-** | 1,041,214,652.03 |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **78,276,400.00** | **83,297,400.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **150,000.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 150,000.00 | - |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 150,000.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 150,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **78,126,400.00** | **83,297,400.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 5,000,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 5,000,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 78,126,400.00 | 78,297,400.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 78,126,400.00 | 78,297,400.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **78,276,400.00** | **77,797,400.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **78,276,400.00** | **77,797,400.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **75,274,694.00** | **77,385,468.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 58,632,983.00 | 60,913,800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 45,665,128.00 | 51,306,800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 12,967,855.00 | 9,607,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,650,244.00 | 7,785,820.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,639,402.00 | 5,408,220.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 550,553.00 | 594,300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 441,692.00 | 453,400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 121,100.00 | 141,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 897,497.00 | 1,188,600.00 |
| 210206 | Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 7,396,067.00 | 6,024,848.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,092,467.00 | 1,264,848.00 |
| 210302 | Түлш, халаалт | 6,303,600.00 | 4,760,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 324,000.00 | 325,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 60,000.00 | 60,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 112,500.00 | 100,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 85,000.00 | 75,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | 90,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 66,500.00 | - |
| **2105** | **Нормативт зардал** | 45,000.00 | - |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 45,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 450,000.00 | 380,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 150,000.00 | 80,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 300,000.00 | 300,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 68,400.00 | 56,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 68,400.00 | 56,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,708,000.00 | 1,900,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,600,000.00 | 1,900,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 108,000.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **3,001,706.00** | **411,932.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 300,000.00 | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 300,000.00 | 200,000.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 2,701,706.00 | 211,932.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 2,701,706.00 | 211,932.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **5,500,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **-** | **6,382,500.00** |

| | | | |
|---|---|---|---|
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **6,382,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 6,382,500.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 5,382,500.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 1,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(6,382,500.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | (882,500.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Өмнөх оны | | Тайлант оны | |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 0.00 | 0.00 | 79179900.00 | 78967968.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 0.00 | 0.00 | 79179900.00 | 77585468.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 0.00 | 0.00 | 78979900.00 | 77385468.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 0.00 | 0.00 | 60913800.00 | 60913800.00 |
| 210101 | Үндсэн цалин | 0.00 | 0.00 | 51306800.00 | 51306800.00 |
| 210102 | Нэмэгдэл | 0.00 | 0.00 | 9607000.00 | 9607000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 0.00 | 0.00 | 7995600.00 | 7785820.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 0.00 | 0.00 | 5618000.00 | 5408220.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 0.00 | 0.00 | 594300.00 | 594300.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 0.00 | 0.00 | 453400.00 | 453400.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 0.00 | 0.00 | 141300.00 | 141300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 0.00 | 0.00 | 1188600.00 | 1188600.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 0.00 | 0.00 | 6025000.00 | 6024848.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210301 | Гэрэл, цахилгаан | 0.00 | 0.00 | 1000000.00 | 1264848.00 |
| 210302 | Түлш, халаалт | 0.00 | 0.00 | 5025000.00 | 4760000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 0.00 | 0.00 | 325000.00 | 325000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 0.00 | 0.00 | 60000.00 | 60000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 0.00 | 0.00 | 100000.00 | 100000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | - | 75,000.00 | 75,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | - | - | 90,000.00 | 90,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | - | 762,500.00 | 380,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | - | 382,500.00 | - |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | - | 80,000.00 | 80,000.00 |
| 210604 | Урсгал засвар | - | - | 300,000.00 | 300,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | - | 58,000.00 | 56,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | - | - | 58,000.00 | 56,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | - | 2,900,000.00 | 1,900,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | - | 1,900,000.00 | 1,900,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | - | 1,000,000.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | - | 200,000.00 | 200,000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | - | 200,000.00 | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | - | 200,000.00 | 200,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | - | - | **1,382,500.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | - | - | 1,382,500.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | - | - | 382,500.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | - | - | 1,000,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | - | 79,179,900.00 | 78,297,400.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | - | - | 78,297,400.00 | 78,297,400.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | - | - | 78,297,400.00 | 78,297,400.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | - | - | 882,500.00 | - |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 120 004 1 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - | 882,500.00 | - |

### 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **-** | **5,000,000.00** | |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **5,000,000.00** | |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | - | 5,000,000.00 | |
| 220001 | Барилга байгууламж | | | |
| 221001 | Их засвар | | | |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 5,000,000.00 | |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 5,000,000.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 5,000,000.00 | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 5,000,000.00 | |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | | | |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн санхүүгийн тайлагнал, бүртгэл хөтлөлттэй холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Э.Одбаясах гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол, дарга, тэргүүлэх аудитор Д.Анхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сэлэнгэ сумын Соёлын төвийн зорилго нь Булган аймгийн соёл урлагийн бодлогын хэрэгжилтийг хангаж, ардын болон орчин үеийн соёл урлагийн үйлчилгээг олон талт хэлбэрээр хүргэж, соёлын бүтээлч үйлвэрлэлтийг нэмэгдүүлэх, нийтийн биеийн тамир, спортоор хичээллэх таатай орчин бүрдүүлэхэд оршино.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус байгууллагад дотоод аудитын нэгж, хариуцсан ажилтан ажилладаггүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зориултот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Сэлэнгэ сумын Соёлын төв 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр тайлант оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардал 62,567.0 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 938.5 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 65 хувиар буюу 610.0 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг гүйцэтгэлийн үе шатанд дахин үнэлэн шинэчлэж тогтоогоогүй болно.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 862,749.3 мянган төгрөгөөр буюу 2.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлттэй гарсан бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.0 | 0.0 | 0.0 |
| Бараа материал | 16,073.9 | 17,854.7 | 1,780.8 |
| Үндсэн хөрөнгө | 163,263.7 | 1,023,359.9 | -861,877.0 |
| **Нийт хөрөнгө** | **179,337.7** | **1,041,214.6** | **-871,396.3** |
| Өр төлбөр | 0.0 | 0.0 | 0.0 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | **179,337.7** | **1,041,214.0** | **-871,396.3** |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **179,337.7** | **1,041,214.0** | **-871,396.3** |

Бараа материалын данс 17,854.7 мянган төгрөг болж 1,780.8 мянган төгрөгөөр өссөн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,023,359.9 мянган төгрөг болж 861,877.0 мянган төгрөгөөр өссөн нь  Иргэдийн хурлын 5/08 дугаар тогтоолоор Соёл спортын цогцолбор барилга үндсэн хөрөнгийнг дансад бүртгэж авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,041,214.0 мянган төгрөг болж 871,396.3 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Сэлэнгэ сумын Соёлын төв нь 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 79,179.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 79,179.9  мянган төгрөгөөр тооцож, төлөвлөн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Тус байгууллагаас хүргүүлсэн төсвийн төслийг 79,179.9  мянган төгрөгөөр баталсан байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх соёлын боловсрол олгох үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр орон нутгийн төсвөөс 78,297.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 77,797.4 мянган төгрөгийг зарцуулж, 211.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 78,967.9 мянган төгрөг буюу 97,9 хувьтай байгаа нь ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 7,785.8 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 6,024.8 мянган төгрөг, хангамж, бараа материалын зардлыг 325.0 мянган төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутаг судлах тэнхимын дэмжлэг Аймгийн засаг даргын дэмжлэгийг 5,000.0 мянган төгрөгийн нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тайлант онд ковид-19 халдварт цар тахалтай холбоотой хязгаарлалт үргэлжилсэн хэдий ч аудит хийх цар хүрээ хязгаарлагдаагүй болно.

### 3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх асуудлууд үүсээгүй байна.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-д хамаарах төсөвт байгууллага нь тус хуулийн 6.1, 6.4-т тус тус заасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Тус байгууллагын 2021 онд Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна

#### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Засгийн газрын "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43-р тогтоол, Нягтлан бодох бүртгэлийн 12-р зүйл, 14-р зүйлийн хүрээнд шалгасан зүйлийн холбогдох шалгуурт нийцсэн байна гэж дүгнэлээ.

**3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**: Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт хэрэгжсэн байна.

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| Цалингийн зардлаас байгууллагад төлөх шимтгэлийг гүйлгэн зарцуулсан | 0.4 | 0.4 | 0.4 | 0.4 | 0 |
| Шилэн дансны хуулийн хэрэгжилтийг баталгаажуулахад 3дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2 дахь заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. | - | - | - | - | - |

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудал байхгүй байна.

## 4. Аудитын илрүүлэлт

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Шилэн дансны хуультай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Сэлэнгэ сумын Соёлын төвийн 2021 онд Шилэн дансны цахим хуудсанд 1 мэдээллийг хугацаа хоцроож шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-д "Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэж заасныг бүрэн хэрэгжүүлээгүй байна

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Шилэн дансны тухай хуулийн холбогдох заалтуудыг хэрэгжүүлэн ажиллах, шилэн дансанд хугацаанд нь мэдээллийг иж бүрэн байршуулж, гарсан зөрчлийг таслан зогсоох зөвлөмж хүргүүлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 06 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

## 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Соёлын төв | 1 | 0 | | | | | | | 1 | 0 |